

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БУС, ХҮНД СУРТАЛ, ЧИРЭГДЭЛТЭЙ БАЙДЛЫН ТАЛААР ИРГЭДИЙН ГОМДОЛ, САНАЛ ХҮЛЭЭН АВАХ 1977 УТАСНЫ 09-Р САРЫН ТАЙЛАН

Утасны судалгааны товч танилцуулга

“ГЛОБ ИНТЕРНЭШНЛ” ТББ нь Авлигатай Тэмцэх Газартай /цаашид “АТГ” гэх/ хамтарч 2007 оны долдугаар сарын 01-ээс эхлэн 6 сарын хугацаатай “Төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй, ил тод байдал” мониторингийн төслийг Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилтээр хэрэгжүүлж эхлэснээс хойш 3 дахь сарын судалгааны үр дүнг танилцуулж байна.

АТГ-аас төрийн байгууллагуудын хүнд суртлыг багасгах, төрийн үйлчилгээг ил тод, хөнгөн шуурхай болгох, иргэдийн оролцоог хангах талаар 18 зүйл бүхий зөвлөмж бичиг боловсруулж 2007 оны дөрөвдүгээр сард төрийн байгууллагуудад хүргүүлсэн билээ. Энэхүү зөвлөмжийн хэрэгжилт ямар түвшинд байгааг тандах зорилгоор төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх байгууллагад ажиглалт, сурвалжлагын болон баримт бичгийн судалгааны энхний шатны үр дүнг гаргаж байна. Мөн төслийн хүрээнд төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээнд гарсан зөрчлийн талаархи гомдол саналыг хүлээн авах 1977 /энгийн ярианы тарифтай/ утсыг 2007 оны 07 дугаар сарын 09–нөөс эхэлж нээлттэй ажиллуулан ирсэн мэдээллийг лхагва, баасан гараг бүрт АТГ-т хүргүүлж, сар бүрээр багцлан тайланг боловсруулж, АТГ болон өөрийн вэб сайтаараа олон нийтэд мэдээлж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.globeinter.org.mn/?cmd=Content&id=700&menuid=327> хаягаар авна уу.

1977 утсанд ирсэн гомдол, саналыг АТГ-аас судлаж үзээд, гомдлын дагуу төрийн байгууллага, албан тушаалтанд үйл ажиллагаандаа гаргасан зөрчил, дутагдлаа нэн даруй арилгах арга хэмжээ авч, эргэж мэдээлэхийг сануулсан шаардлага хүргүүлэн ажиллаж байна. АТГ-аас утасны судалгааны үр дүнд дүгнэлт хийн, 2007 оны 9 сард иргэдийн гомдол, бухимдлыг хамгийн их төрүүлж буй газрын албадуудад анхаарлаа хандуулж, тэдэнтэй хамтран “Иргэдэд үйл ажиллагаагаа нээлттэй ил тод болгоё” уриан дор 20 хоногийн аян зохион байгуулж, зарим нааштай үр дүнд хүрч байна.

2007 оны 09 дугаар сарын 01-ээс 30 хүртэлх хугацаанд 1977 утсаар иргэдээс нийт 68 гомдол, 1 саналыг авч, цаг тухайд АТГ-т хүргүүллээ.

Гомдол өгсөн иргэдийн 62 нь Улаанбаатар хотоос, 6 нь хөдөө орон нутгаас холбогдож мэдээлэл өгсөн. 68 иргэнээс 10 нь урьд нь тухайн байгууллага албан тушаалтанд хандаж байсан ба эдгээр 10 иргэний дийлэнх хувь нь сүүлийн удаа хандаж байгаатайгаа ижил болон харин үлдэх хувь нь өөр бусад асуудал шийдвэрлүүлэх зорилготой байв. Зохих журмын дагуу нэг иргэн дунджаар 6 удаа очиж байсан хэдий ч тэд бүгд авах ёстой үйлчилгээгээ авч чадаагүй нь хангалтгүй үзүүлэлт юм. Энэ сард холбогдсон иргэдийн дийлэнх нь замын цагдаагийн газар, боловсролын газруудад хандаж байсан байна.

Байгууллагын тухай мэдээлэл

Утсанд холбогдсон иргэдийн 25 хувь нь улсын, 20 хувь нь нийслэлийн, 55 хувь нь дүүрэг сумдын хэмжээнд үйл ажиллагаагаа иргэдэд хүргэдэг төрийн байгууллагад хандсан. Өмнөх сарынхтай харьцуулбал аймаг, нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаагаа иргэдэд хүргэдэг байгууллагуудын эзлэх хувь цөөрч; улс, дүүрэг сумдын байгууллагын албан тушаалтнуудын зөрчилтэй үйл ажиллагаатай холбоотой гомдол 5 - 7 коэффицентээр өссөн байна. Харин анхан шатны /баг, хороод/ байгууллагын албан тушаалтантай холбоотой гомдол ирсэнгүй.

Хүнд суртал гарган иргэдийг чирэгдүүлсэн төрийн байгууллагуудыг үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл 18 хувь нь засаг даргын тамгын газрууд, 36 хувь нь газрын албад болж байна.

Мөн байгууллагуудыг үйл ажиллагааных нь цар хүрээгээр нь авч үзэхэд аймаг нийслэл (10.1%) болон сум дүүргийн газрын албад (26.1%), сум дүүргийн засаг даргын тамгын газруудын (17.4%) үйл ажиллагаатай холбоотой иргэдийн гомдол дийлэнх хувийг эзэлж байна.

Албан тушаалтны тухай мэдээлэл

Зөрчил гаргасан албан тушаалтнуудыг авч үзвэл мэргэжилтэн, шинжээч, байгцаагчид (53.6%) зэрэг төрийн захиргааны байгууллагын гүйцэтгэх болон төрийн улс төрийн байгууллагын анхан шатны удирдах албан тушаалтан (10.1%) мөн болосврол, соёлын байгууллагуудын мэргэжилтэн зэрэг төрийн үйлчилгээний дунд шатны түшмэд (8.7%) байгаа бөгөөд иргэдээс ирүүлсэн гомдлын үнэмлэхүй хувь нь дээр дурьдсан албан тушаалтантай холбоотой байна.

Төрийн байгууллагад иргэдийн хандсан зорилго

Утсанд хандсан иргэдийн 25 хувь нь өмч эзэмших эрхийн бичиг авах, 14 хувь нь аюулгүй амьдрах орчноо хангуулах, 12 хувь нь бичиг баримт бүрдүүлэх, авах зорилгоор тухайн байгууллага, албан тушаалтанд хандсан гэж хариулсан болно.

Гомдол гаргаж байгаа үндэслэл

Иргэдийн 27 хувь нь тэдний хандсан байгууллагууд нь өөрийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу шийдвэрлэвэл зохих асуудлаа шийдвэрлэж өгөхгүй байгаа; 21 хувь нь албан тушаалтнууд хүнд суртал чирэгдэлтэй, 20 хувь нь байгууллагын үйл ажиллагааны дүрэм журам ба хуульд заасан хугацаандаа шийдвэрлэж өгөхгүй байна, 11 хувь нь албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглаж улсын болон иргэдийн эд хөрөнгийг хувьдаа завшиж байна гэсэн үндэслэлээр гомдол гаргажээ.

Төрийн байгууллагыг цар хүрээгээр харьцуулбал улс, нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг байгууллагууд асуудлыг хугацаанд нь шийдвэрлэж өгөхгүй удаах, хуулийн дагуу шийдвэрлэж өгөхгүй, хүнд суртал гаргах гэсэн бол, сум дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд хугацаанд нь

шийдвэрлэж өгөхгүй удаах, үндэслэлгүйгээр олон нэмэлт төлбөр хураамж авах, хуулийн дагуу шийдвэрлэж өгөхгүй, хүнд суртал гаргах зэрэг зөрчлийн эзлэх хувь нь улс нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын талаар ирүүлсэн иргэдийн гомдлоос 2-оос 3 дахин их байна.

Мөн байгууллагуудыг үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл газрын албадад хугацаанд нь шийдвэрлэж өгөхгүй удаах, хуулийн дагуу шийдвэрлэж өгөхгүй, хүнд суртал гаргах зөрчил; засаг даргын тамгын газруудад хугацаанд нь шийдвэрлэж өгөхгүй удаах, үндэслэлгүйгээр олон нэмэлт төлбөр хураамж нэхэх, албан тушаалаа урвуулан ашиглаж улсын болон бусдын эд хөрөнгийг өөртөө завших хууль дүрмэнд заасны дагуу асуудлыг шийдвэрлэж өгөхгүй, хүнд суртал гаргах нь элбэг тохиолджээ.

Төрийн байгууллагад хандаж асуудлаа шийдвэрлүүлэхийн тулд зарцуулсан хугацаа

Утсаар холбогдсон иргэдийн 13 хувь нь 4-өөс 6 сар, 55 хувь нь 7 сараас 1 жил, 9 хувь нь 1-ээс 2 жил, 23 хувь нь 2-оос дээш жил тус тус болж байна.

Энэ сард утсаар ирүүлсэн иргэдийн гомдлын дийлэнх нь асуудлыг цаг хугацаанд нь шийдэж өгөхгүй байгаатай холбоотой. Үүнийг байгууллагыг цар хэмжээгээр нь авч үзвэл асуудлаа шийдвэрлүүлэхээр 4-өөс 6 сар болж байгаа иргэдийн 56 хувь нь сум дүүргийн; 7-оос 1 жил хүлээж байгаа иргэдийн 40 хувь нь улс мөн 45 хувь нь сум дүүргийн; 1-ээс 2 жил болж байгаа иргэдийн 67 хувь нь сум дүүрэг; 2-оос дээш жил хүлээн байгаа иргэдийн 75 хувь нь сум дүүргийн байгууллагуудад хандсан байна.

Гомдол гаргагч иргэдийн 11 нь буюу нийт энэ сард гомдол гаргасан иргэдийн 16% нь нэрээ нууцлахыг хүссэн хүссэн байна.

Иргэдийн саналын тухай мэдээлэл

1 иргэн АТГ-т хандахдаа: Татварын албанд тайлангаа өгөхөд их чирэгдэлтэй байдаг учраас зөвхөн байгууллагуудын тайлан хүлээж авах ажилтнуудыг тодорхой хугацаатай томилж ажиллуулах санал дэвшүүлжээ.

Судалгааны дэлгэрэнгүй харьцуулсан тоон мэдээллүүдийг хавсралтаас харна уу

2007 оны 10 сарын 05-ны өдөр

* * *